



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт 19,954,000.00 (арван есөн сая есөн зуун тавин дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий барилгын их засварын ажлыг Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн холбогдох хөрөнгөд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн захирагч хурандаа Н.Бат-Эрдэнэ, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004807

9-r huraldaan.docx